



Хэвлэлийн тойм
2022 оны 9-р сарын 21

Холбоо барих
9909-1557

**АмЧам Монгол 9-р сарын ээлжит хурлаар
“Mine-golia-г хэн үгүй хийсэн вэ?” сэдвээр салбарын уналт, ирээдүйн талаар хэлэлцэв**



УЛААНБААТАР, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2022 оны 9-р сарын 20-нд “Хэн Mine-golia-г үгүй хийсэн вэ?” сэдэвт панел хэлэлцүүлгийг Уул Уурхайн долоо хоногийн хүрээнд зохион байгууллаа.

Уг уулзалт хэлэлцүүлгийн хэлбэрээр явагдсан бөгөөд модераторын үүргийг АмЧам Монголын ТУЗ-ийн дарга Жэймс Лиотта гүйцэтгэж, оролцогч нар болох, Монголын нүүрсний ассоциацийн гүйцэтгэх захирал Ж.Золжаргал, Монголын уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа, Оюу Толгойн Гадаад харилцаа, харилцаа холбооны ерөнхий менежер Э.Лхагва нар панелистын суудлаас үг хэлэв. Уулзалтын нээлтийн үеэр “Mine-golia” хэрхэн өнөөгийн уналтад орсон талаар дэлгэрэнгүй танилцуулга хийгдэв.



Ноён Жэймс Лиотта илтгэлээсээ хэд хэдэн гол санааг онцлон дурдав, тухайлбал хууль эрх зүйн орчинд хийгдсэн цуврал өөрчлөлтүүд, засгийн газрын янз бүрийн түвшин дэхь авлига, шүүх засаглалын чадамжгүй байдал зэрэг нь бусад хүчин зүйлүүдтэй хавсарч уул уурхайн салбарыг уналт руу хөтлөхөд их нөлөөлсөн гэлээ. “Гадаадын хөрөнгө оруулалт буурч, гадаадаас хөрөнгө оруулсан уул уурхайн хэд хэдэн томоохон

компаниуд Монголоос гарсны дараа үлдсэн зүйл бол өмнө нь тэдний эзэмшиж байсан тусгай зөвшөөрөлтэй, хувийн хэвшлийн хөгжүүлж байсан ордууд бүхий төслүүдийг нэгтгэсэн “Эрдэнэс Монгол-штайн” нэртэй төрийн өмчит уул уурхайн томоохон аж ахуйн нэгж байгуулсан явдал байв. Эдгээр нутаг буцсан компаниуд нь хурдацтай хөгжиж байсан Mine-golia-ын гол хөдөлгөгч хүч байсан” хэмээн тэмдэглээд “чөлөөт зах зээлийн эдийн засагт хувийн хэвшлийнхний эдийн засгийг хөгжүүлэх, авлигыг таслан зогсооход суурилсан хууль тогтоомжийн экосистем сайн хөгжүүлэх нь Монгол Улсад хөрөнгө оруулалтыг сэргээх хэрэгсэл болно” гэж ноён Лиотта хаалтын үгэндээ онцлов.



Монголын уул уурхайн холбооны Гүйцэтгэх захирал ноён Золжаргал хэлэхдээ “Монгол Улсын хөрөнгө оруулалтыг татахдаа зөөлөн дэд-бүтцийн шинэчлэлтийг орхигдуулах нь учир дутагдалтай ба салбарын бодлогын хүрээнд хийгдэх ажлуудыг үл тоомсорлож болохгүй” гэж тэмдэглэв. Монголын уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа хэлсэн үгэндээ, “шинээр хөрөнгө оруулагчдыг татахын тулд амжилттай яваа компаниуд, кейсүүдийн судалгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй” гэлээ. Оюу Толгой компанийн Гадаад харилцааны ерөнхий менежер Э. Лхагва “Би Mine-golia-г бүрэн устгасан гэдэгт итгэхгүй байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд хичээнгүйлэн ажилласан хөрөнгө оруулагчид, компаниудыг, тэр дундаа бид үргэлжлүүлэн ажилласаар байгааг ойлгох нь чухал. Гэсэн хэдий ч бидний дөнгөж өнөөдөр харсан илэрхий баримтуудыг хайхрахгүй байж болохгүй бөгөөд эдгээр алдаануудаас суралцах нь ирээдүйд сургамж болно гэж найдаж байна” хэмээн хэлэв.

Эцэст нь дүгнэхэд “Mine-golia”-г засгийн газрын дэмжлэг, хувийн хэвшлийн оролцоотой бүтээсэн хэдий ч бодлого тодорхойлогчдын алдаатай үйл ажиллагаа өнөөдрийн зогсонги байдал, уналтад ихээхэн нөлөөлсөн гэдгийг онцлов. Нөхцөл байдал хэдий ийм байгаа боловч ирэх арван жилд сэргэх боломж, итгэл найдвар байгаа бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь салбарыг сэргээж, эрүүл болгоход чухал үр нөлөөтэй болохыг дүгнэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр

ажилладаг бие даасан, гишүүдээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.